

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

**УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** ЗАВХАН СУМЫН ТОХИЖИЛТ

**Төслийн дугаар:** УВАОНӨГ/202009109

Сайншанд хот  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.10.23

**Увс аймгийн Завхан сумын Засаг даргын Тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Увс аймгийн Завхан сумын тохижилтын ажил**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 11-р сарын 3-ний өдрийн 14 цаг 00 минутаас** өмнө хаягаар tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 11-р сарын 3-ний 14 цаг 55 минутад** нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.  
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймаг Завхан сумын ЗДТГ-ын байр Утас:89338977,88458876**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг

<b>залруулах</b>	шалгаж дараах байдлаар залруулна:
	<p>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p> <p>(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.</p>
	<p>6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.</p>
<b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>	<p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p>
<b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>	<p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p>

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн /2019 он/ санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт ирүүлэх: Аудитаар ороогүй бол тайлбар албан бичиг ирүүлэх</p> <p>Сүүлийн [2] жилийн /2018,2019 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хуулбар/ ирүүлэх</p> <p>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018,2019 оны борлуулатын орлогыг цахим системээс дуудаж үзнэ/</p> <p>Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь: төсөвт өртгийн 50 хувиас доошгүй байх.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b><i>БХБСайдын -2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /БА-8.1/, ажилбарын заалт бүхий хүчинтэй хугацаа дуусаагүй барилгын тусгай зөвшөөрөлтэй байна.</i></b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b><i>Завхан сум, ЗДТГ-ын байр Санхүү албаны даргын өрөөнд</i></b>  Огноо: <b><i>2020 оны 11 дугаар сарын 3-ний өдөр</i></b>  Цаг: <b><i>14 цаг 00 минут</i></b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b><i>Завхан сум, ЗДТГ-ын байр Санхүү албаны даргын өрөөнд</i></b>  Огноо: <b><i>2020 оны 11 дугаар сарын 3-ний өдөр</i></b>  Цаг: <b><i>14 цаг 55 минут</i></b></p>

<p><b>ТӨЭЗ 2.3</b></p>	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар</li> <li>2. Оролцогч компанийн танилцуулга</li> <li>3. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/</li> <li>4. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>5. Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар /гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй/</li> <li>6. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл, иргэний үнэмлэхийн хуулбар</li> <li>7. Харилцагч бүх банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>8. Татварын газрын тодорхойлолтыг цахим системээс дуудаж үзэх тул өргүй байх шаардлагатай</li> <li>9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>10. Нийгмийн даатгал болон татварын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулах</li> <li>11. Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл</li> <li>12. Дээрх шаардлагатай тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш авсан байх</li> <li>13. Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх</li> <li>14. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>15. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай.</li> <li>16. ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</li> </ol>
<p><b>ТӨЭЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Завхан суманд тохижилтын ажлын УВАОНӨГ/202009109 дугаар бүхий нэг багц ажил</b></p>

## **Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

### **Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж**

#### **Зорилт**

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### **Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

## Долоо. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх
  2. Төслийн менежерийн шийдвэр
  3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх
  4. Аюулгүй байдал
  5. Зааварчилгаа
  6. Маргааныг шийдвэрлэх
  7. Ажлын хөтөлбөр
  8. Зөрчил, гологдол илрүүлэх
  9. Зөрчил, гологдол арилгах
  10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
  - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн захиалагч байгууллагын дарга шийдвэрлэнэ.
  - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
  - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
  - 4.2. Гүйцэтгэгч буй ажлаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
  - 5.1. Захиалагч байгууллагын гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
  - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
- 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд нь захиалагч байгууллагад хүргүүлж батлуулна.
  - 7.2. Ажлын захиалагч байгууллага батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад захиалагч байгууллагад хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
  - 8.1. гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. захиалагч байгууллагад зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
  - 9.1. захиалагч байгууллага гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
  - 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг захиалагч байгууллагийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
  - 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн захиалагч байгууллагын заасан хугацаанд багтааж арилгаагүй бол захиалагч байгууллага зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. захиалагч байгууллага шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг тавих бөгөөд захиалагч байгууллага ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Гүйцэтгэгч байгууллага ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө захиалагч байгууллагад хүргүүлнэ
- 17. Гэрээг цуцлах**
- 17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг захиалагч байгууллага батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 7 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг захиалагч байгууллага гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

**18. Гэрээг  
цуцалсан үед  
хийх төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол захиалагч байгууллага гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>**

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах УВАОНӨГ/202009109</b>
ГЕН 2.1	<b>Увс аймгийн Завхан сумын тохижилтийн ажил</b>
ГЕН 3.1	Захиалагч байгууллага ЗДТГ
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <b>2020.11.11</b>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>2020.12.10</b>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>[ажлын 5]</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>36 сар</b> байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>[ 1 хувь]</b> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>[10 хувь]</b> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>[2020.11.1-ний дотор гаргаж өгнө.</b>  Гүйцэтгэлийн зургийг <b>[2020.11.11]-ний дотор гаргаж өгнө.</b>
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[1 хувь]-иар тооцно.</b>

#### Ажлын даалгавар

- 1.Явган зам:Одоо байгаа явган замтай уялдуулан явган зам болон амарч суух талбай бүхий гадна тохижилтын зургыг төлөвлөсөн ба нийт 558,6 м2 тахлбайд явган замын хэлбэршүүлсэн хавтан хийх шинээр 207,51 м урт явган замын хашилгыг ашиглана. Явган замын бетон дэр В.10 7,05м2 цутгах
- 2:Хөшөөний суурь ,алсыг харагчийн шат ,талбай өнгөлөх. Одоо байгаа хөшөөний суурь өнгөлгөөтэй чулуу хавтан 17 м2 хийгээд хаяг хийлгэн наах.Алсыг харагчийн шатны марш барзгар гадаргуутай чулуун хавтангаар 13,5м2 өнгөлөх.Мөн алсын харагчийн талбайг 115,75м2 явган зам гоёлын хавтангаар өнгөлөх .
- 3.Хашаа хашааны хаалга. Одоо байгаа хашааг 64 м буулгаад буцааж ашиглах .Хэвээр үлдэх хашаа 40,88 м Шинээр хийх хашаа 88 м хашааны жижиг хаалга 2 ш хийх
- 4.Усан оргилуур цэцгийн мандал. Зургаас үзэх
- 5.Саравч Хүмүүсийн амарч тухлах , хүмүүс хоорондын харилцааг тухтай байлгах зорилгоор гадна тохижилтонд амралтын зориулалттай талбайтай уялдуулан төлөвлөсөн бөгөөд ерөнхий төлөвлөгөөнд тусгасан байрлалд зургын дагуу чанартай хийж гүйцэтгэх
- 6.Сүүдрэвч зургын дагуу хийх
- 7.Сандал болон хогын сав Зам талбай ногоон байгууламжтай уялуулан төлөвлөсөн сандал хогын савыг зургын дагуу төлөвлөгөөнп тусгасан байршилд угсарч хийнэ.
8. Гэрлэн хаяг. Эрзэл мэндийн төв,Засаг Даргын Тамгын газар, Соёлын төвийг монгол бичгээр гэрлэн хаяг хийх, Жич. Захиалагч байгууллагатай зөвшилцөж байгууллагын нэрийг тодруулах

Ажлын даалгавар

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Алсыг харагчийн талбайг гоёлын явган хүний замын өнгөт хавтангаар хийх	м2	115,75
2	Алсыг харагчийн өнгөт хавтаны суурьт элсэн дэвсгэр хийх	м3	4,52
3	Анкерын боолт суулгах /тэлэгчтэй/	тн	0,002
4	Алсыг харагчийн талбайн хашлага дэр цутгах м100	м3	1,17
5	Алсыг харагчийн шатныг барзгар чулуугаар өнгөлөх	м2	13,5
6	Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх	м2	558,6
7	Явган замын хашлага тавих	у/м	280
8	Хашлагын бетон дэр цутгах м100	м3	7,05
9	Элсэн дэвсгэр хийх	м3	22,34
10	Хөшөөний сууринд чулуун хавтан наах	м2	17
11	Хөшөөний хаяг хийх	Иж бүрдэл	1
12	Сандал лакаар будах	м2	3,6
13	Хогийн сав тавих	ш	8
14	Сандал угсрах 1=1300	ш	3
15	Сандалын бетон дэр цутгах м100	м3	1,014
16	Гэрлийн тулгуурын төмөр бетон хөл цутгах	м3	1,34
17	Нарны эрчим хүчний 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах	ком	4
18	ПВ 3/1*4/ мм2 зэс голтой кабель угсрах	м	180
19	Пластмасан хоолой ф22 мм угсрах /далд угсралтын/	м	60
20	Хаалганы шонгийн нүхийг гараар ухах	нүх	44
21	Хашаа барих	м	88,01
22	Төмөр жижиг хаалга хийх	ш	1
23	Хашааны төмөр рам будах	м2	95,4
24	Хашааны хуучин бетон суурь задлаж буулгах	м3	0,86
25	Хашааны шонгийн бетон цутгах	м3	2,73
26	Үндэс, шороотой мод бут сөөгийг 0,5х0,4 хэмжээтэй стандартын нүхэнд суулгах	Ш	98
27	Байгууллагуудад гэрэлтдэг хаяг хийх	Иж бүрдэл	3

Саравч, сүүдрэвч, сандал хийх ажил

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Саравчны багана суух суурь цутгах В10	М3	1,245
2	Саравч угсрах 3ш	м3	2,44
3	Саравчны шалыг гоёлын явган хүний замын өнгөт хавтангаар хийх	м2	28,89
4	Саравчны дээвэр осп хавтангаар бүрэх	м2	37,5
5	Уян битум шинглас дээвэрийг угсрах	м2	96
6	Сүүдрэвчны багана суух суурь цутгах В10	м3	0,828
7	Жижиг сүүдрэвч угсрах 2ш	м3	0,33
8	Сүүдрэвчны кв төмөр хийх	тн	1,359
9	Сүүдрэвч, сандалны модон гадаргууг лакаар будах	м2	30
10	Сүүдрэвч, сандалны төмөр гадаргууг төмрийн будгаар будах	м2	26,5

Усан оргилуур, цэцгийн мандалын ажил

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих	Тоо
---	---------------------	--------	-----

		НЭГЖ	ХЭМЖЭЭ
1	Усан оргилуур цэцгийн мандалд бетон хана цутгах	м3	2,91
2	Усан оргилуур угсрах	ш	1
3	Бетон шал В10	м3	0,678
4	Усан оргилуур, цэцгийн мандалд гантиг наах	м2	16
5	Ус тусгаарлагч хийх	м2	20,72
6	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	20,72
7	D=40мм голчтой ган хоолой угсрах	м	1
8	D=25мм голчтой ган хоолой угсрах	м	7
9	D=20мм голчтой цайрдсан ган хоолой угсрах	м	18
10	Шилжүүлэг ф40/25 угсрах	ш	1
11	Шилжүүлэг ф40/20 угсрах	ш	1
12	Насос угсрах	ш	1
13	Ус цацруулагч толгой угсрах	ш	18
14	Зураг төсвийн үнэ	Т	2145000
15	Тохижилтын ажлын үнэ	Т	77855000
16	Тендерийн үнэ	Т	80000000













